



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
ХАРЬАА БАЯНХОНГОР
АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

УУЛ УУРХАЙН НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ХӨРӨНГӨ
ТӨВЛӨРҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ, ҮР ДҮН
АУДИТЫН КОД: УАГ-ГАГ/2015/05-ГА-БХ





Гарчиг

Тайланг бэлтгэсэн:

Үндэсний Аудитын газрын
харьяа

Аауи өи і ай д аймгийн
Аудитын газрын

дарга, тэргүүлэх аудитор

Ё. Сугаррагчаа

Аудитын менежер

А.Оюуай аа

Ахлах аудитор Б.Мөнхбат

Аудитор Д.Мөнх-эрдэнэ

Шинжээч Б.Цэрэнчимэд

2015оны 10 дүгээр сарын 21

Тайланг Аймгийн аудитын
газрын

Цахим хуудаснаас үзнэ үү:

www.audit.mn

Аудитын тайлантай
холбоотой асуудлаар

нэмж тодруулах, асууж
лавлах зүйл байвал

70442584, 70442424
дугаарын утсаар харилцана
уу.

ХАЯГ: Үндэсний аудитын
газрын харьяа

Аауи өи і ай д аймгийн
Аудитын газар

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ.....1

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН.....2

АУДИТЫН ДҮН.....4

Зорилт 1: Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй ААН-үүд 2013-2014 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөө боловсруулан батлуулсан, нөхөн сэргээлтийн барьцааг хайгуулын тусгай зөвшөөрөлтэй ААН-үүд бүрэн, ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй зарим компани дутуу төвлөрүүлсэн бөгөөд байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу нөхөн сэргээлтийг Бритиш майнинг ХХК, Универсал коппер ХХК, Жи энд юу голд ХХК, Жамп ХХК-иуд хийгээгүй байна.....4

Зорилт 2: Эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийх аж ахуйн нэгжийг журмын дагуу сонгон шалгаруулсан боловч журмын 2.2, 8.3 дах заалтыг хэрэгжүүлээгүйгээс нөхөн сэргээлт хийх газрыг газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаагүй, ААН-дээс барьцаа хөрөнгө аваагүй, сонгон шалгаруулалтад шалгарсан ААН-үүд нь өмнөх онд нөхөн сэргээлт хийсэн талбайдаа сумын Засаг даргатай гэрээ байгуулан дахин нөхөн сэргээлт хийх нэрээр олборлолт явуулж байна.....13

Зорилт 3: Уул уурхайн хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй ААН-үүдээс 2013, 2014 онд 687,4 сая төгрөг, эвдэрсэн газрын нөхөн сэргээлт хийсэн ААН-үүдээс 2014 онд 1921,0 сая төгрөгийн хандивын хөрөнгө оруулалт хийгдсэнийг бүртгэл тайланд тусгасан боловч Төсвийн тухай хуулийн 25.8-д заасны дагуу мэдээлээгүй байна.....19

Зорилт 4: Тусгай зөвшөөрөл бүхий ААН-үүд гэрээгээр хүлээсэн үүрэг, хяналт шалгалтын байгууллагаас гаргасан шийдвэрийг биелүүлээгүй, орон нутгийн болон холбогдох мэргэжлийн байгууллага гаргасан шийдвэрийнхээ хэрэгжилтийг тооцохгүй байгаагаас хяналт шалгалтын ажлын үр дүн бүрэн гарахгүй байна.....23

АУДИТЫН ДҮГНЭЛТ.....27

ЗӨВЛӨМЖ.....29

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ИТХ	ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ
ЗДТГ	ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
ҮАГ	ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
ААН	АЖ АХУЙН НЭГЖ
МХГ	МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР
БОАЖГ	БАЙГАЛЬ ОРЧИН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР
ХХК	ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ
ТББ	ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА
ХАМОДХ	ХУВИАРАА АШИГТ МАЛТМАЛ ОЛБОРЛОГЧДЫГ ДЭМЖИХ ХОЛБОО

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

1. Аудитын нэр: Уул уурхайн нөхөн сэргээлтийн хөрөнгө төвлөрүүлэлт, зарцуулалт, үр дүн

2. Аудитын код: ҮАГ-ГАГ/2015/05-ГА-БХ

3. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх: Аудитыг УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2014 оны 20 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2015 онд нийлүүлэх аудитын болон ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон ҮАГ-ын бүрэн эрхийн хүрээнд хийв.

4. Аудитын зорилт: Уул уурхайн нөхөн сэргээлтийн хөрөнгийн төвлөрүүлэлт, зарцуулалт, үр дүнд үнэлгээ, дүгнэлт өгч дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулна. Аудитыг дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэв. Үүнд:

- Уул уурхайн нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийг хууль тогтоомжийн дагуу тооцож төвлөрүүлсэн эсэх,
- Төвлөрүүлсэн хөрөнгийг холбогдох хууль журамд заасны дагуу зарцуулсан эсэх,
- Төв орон нутгийн захиргаа, мэргэжлийн болон тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хуулиар хүлээсэн үүрэг хэрэгжиж буй эсэх,

Үндэсний аудитын газраас ирүүлсэн төлөвлөгөөний дээрх дэд зорилтыг хангахын тул Баянхонгор аймгийн Аудитын газар дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэв. Үүнд:

- Уул уурхайн компаниуд хууль тогтоомжийн дагуу байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөө батлуулж нөхөн сэргээлтийн ажлаа гүйцэтгэсэн эсэх,
- Аймгийн ИТХ-ын хуралдааны 2014.05.26-ны өдрийн 9/2 тоот тогтоолоор “Эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийх аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулж, үйл ажиллагаанд нь хяналт тавих журам”-ыг дагуу эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийх эрх авсан компани аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний дагуу нөхөн сэргээлтийг хугацаанд нь бүрэн хийсэн эсэх,
- Эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийх эрх авсан компани ИТХ-ын баталсан журмын дагуу сайн дурын үндсэн дээр орон нутагт хөрөнгө оруулалт болон хандив өгсөн эсэх, зарцуулалтын байдал үр дүн,
- Орон нутгийн захиргаа, мэргэжлийн болон тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд хуулиар болон гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлж буй эсэх,

5. Хамрах хүрээ: Аудитад 2013-2014 онд Уул уурхайн нөхөн сэргээлтийн хөрөнгө төвлөрүүлэлт, зарцуулалт, үр дүнгийн биелэлтийг хариуцсан төрийн байгууллагуудын /Аймгийн ЗДТГазар, БОАЖГазар, МХГазар ба бусад/ тайлант жилүүдэд хэрэгжүүлсэн арга хэмжээ, хамтын ажиллагаа, шийдвэр гаргалт, тэдгээрийн үр нөлөө, хэрэгжилтийн талаарх тайлан, мэдээ, ажлын баримт материал, хөндлөнгийн хараат бус байгууллагын судалгаа, шинжилгээний үнэлгээ дүгнэлтийг ашиглав.

6. Үндсэн мэдээлэл: Ашигт малтмалын газрын статистик мэдээгээр Баянхонгор аймагт ашиглалтын тусгай зөвшөөрлийн тоо 70, хайгуулын тусгай зөвшөөрлийн тоо 110 байгаа

боловч 2013 онд 8 аж ахуйн нэгж 428,8 сая, 2014 онд 10 аж ахуйн нэгж 387,7 сая төгрөгийн төсөвтэй байгаль орчныг хамгаалах ажлын төлөвлөгөөг аймгийн Байгаль орчны газарт ирүүлсэн байна. Аймгийн Засаг даргын тамгын газрын Хөгжлийн бодлогын хэлтсээс авсан урьдчилсан судалгаагаар ашиглалтын 71 тусгай зөвшөөрөл, хайгуулын 83 тусгай зөвшөөрөл бүртгэгдсэн байна.

Тусгай зөвшөөрлөөр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдээс гадна Аймгийн ИТХ-ын хуралдааны 2014.05.26-ны өдрийн 9/2 тоот тогтоолоор “Эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийх аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулж, үйл ажиллагаанд нь хяналт тавих журам”-ыг баталсны дагуу аймгийн Засаг дарга 2014 онд сонгон шалгаруулалт явуулж 14 аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан ажилласан байна.

7. Эрсдэлийн үнэлгээ: Аудитын төлөвлөлтийн үе шатны явцад судалсан баримт материал, хийсэн урьдчилсан дүн шинжилгээ, ярилцлагад үндэслэн ерөнхий эрсдэлийг “ДУНД” гэж үнэлэв.

8. Аудитын арга зүй: Аудитыг Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүйг баримтлан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу холбогдох байгууллагын албан тушаалтантай ярилцлага хийх, санал асуулга авах, шалгуурыг бодит байдалтай харьцуулах, статистик судалгааны материалын дүн шинжилгээ хийж, аудитын горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

9. Аудитад ашиглах хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт: Дараах хууль эрхийн акт, бодлогын бичиг баримтыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав:

- Монгол Улсын Үндсэн хууль
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль
- Ашигт малтмалын тухай хууль
- Газрын хэвлийн тухай хууль
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
- Байгаль орчны нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам
- Уул уурхайн нөхөн сэргээлттэй холбоотой стандартууд
- Аймгийн ИТХ-ын хуралдааны 2014.05.26-ны өдрийн 9/2 тоот тогтоолоор “Эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийх аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулж, үйл ажиллагаанд нь хяналт тавих журам”

10. Аудит хийх хугацаа: Аудитын 2015 оны 09 дугаар сарын 10-наас эхэлж 10-р сарын 23-нд дуусгаж тайланг аймгийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулан ҮАГын ГАГазарт хүргүүлэв.

АУДИТЫН ДҮН

Ерөнхий зүйл: Үндэсний аудитын газрын дэд дарга, тэргүүлэх аудитор Б.Баттуяагаас ирүүлсэн албан тоотын дагуу “Уул уурхайн нөхөн сэргээлтийн хөрөнгө төвлөрүүлэлт, зарцуулалт, үр дүн”-д хийх гүйцэтгэлийн аудитад дээрх дэд зорилтыг боловсруулан гүйцэтгэлийн аудитын газарт хүргүүлэн баталгаажуулсан.

Аудитын дэд төлөвлөгөөг 2015 оны 09-р сарын 21-ний өдөр аймгийн Засаг дарга Д.Жаргалсайханд танилцуулахад дэд зорилтод орсон *“Аймгийн ИТХ-ын хуралдааны 2014.05.26-ны өдрийн 9/2 тоот тогтоолоор “Эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийх аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулж, үйл ажиллагаанд нь хяналт тавих журам”-ын дагуу эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийх эрх авсан компани аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний дагуу нөхөн сэргээлтийг хугацаанд нь бүрэн хийсэн эсэх”* гэсэн асуудал гүйцэтгэлийн аудитын Ерөнхий төлөвлөгөөний зорилтот асуудалтай хамааралгүй байгаа талаар Засаг дарга саналаа илэрхийлсэн бөгөөд харилцан ярилцаж зөвшилцсөний дүнд дэд төлөвлөгөөний дагуу аудитыг гүйцэтгэсэн болно.

Энэ асуудлын талаар Гүйцэтгэлийн аудитын газрын аудитор С.Одонцэцэгт аудитын явцад мэдээлж ажилласан.

Аудитыг аймгийн Аудитын газрын холбогдох ажилтнуудаас гадна говийн сумдад аймгийн БОАЖГазрын мэргэжилтэн Б.Наранбаатар, хангайн сумдад аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга Б.Гантулга, БОАЖГазрын дарга Х.Бат-Оргил, мэргэжилтэн Б.Наранбаатар, МХГ-ын улсын байцаагч Г.Энхбаяр нарын бүрэлдэхүүнтэйгээр хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн 2013-2014 оны Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтийг газар дээр нь үзэж тулган шалгалаа.

Уул уурхайн үйл ажиллагаа эрхлэгч ААН-үүд төрийн байгууллагуудад өгсөн хандивын талаарх албан ёсны мэдээллийг өгөхөөс татгалзсан тул аймгийн ЗДТГазрын Хөгжлийн бодлогын хэлтэс болон сумдын ЗДТГазраас авсан нэг талын мэдээллээр тайланд тусгагдсан болно.

Зорилт 1: Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй ААН-үүд 2013-2014 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөө боловсруулан батлуулсан, нөхөн сэргээлтийн барьцааг хайгуулын тусгай зөвшөөрөлтэй ААН-үүд бүрэн, ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй зарим компани дутуу төвлөрүүлсэн бөгөөд байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу

нөхөн сэргээлтийг Бритиш майнинг ХХК, Универсал коппер ХХК, Жи энд ю голд ХХК, Жамп ХХК-иуд хийгээгүй байна.

Зорилт 1.1: Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 2013-2014 онд үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгжүүд нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөг холбогдох газраар батлуулсан боловч хайгуулын тусгай зөвшөөрөлтэй 3, ашиглалтын 5 аж ахуйн нэгж орон нутгийн төрийн захиргааны байгууллагуудад байгаль хамгаалах төлөвлөгөөг хүргүүлээгүй байна.

Хайгуул: Баянхонгор аймгийн хэмжээнд 2015 оны 9-р сарын мэдээгээр хайгуулын 125 тусгай зөвшөөрөл байгаагаас 2013-2014 онд Хүрээмарал сумын “Салхитын ам-1” талбайд Хонгорхайрхан эрдэнэс ХХК, Шинэжинст сумын “Зуун мод”, “Хөндий”, “Цэнхэр номин” талбайд Эрдэнэмонгол ХХК, “Их онгон”, “Үхэр чулуут” талбайд Бритиш майнинг ХХК, “Байц” талбайд Гобикоул энд энерги ХХК, Баянговь сумын “Сээрийн нурууны ар” талбайд Универсал коппер ХХК-иуд хайгуулын 7 талбайд үйл ажиллагаа явуулж, үлдсэн тусгай зөвшөөрөлтэй 118 хайгуулын талбайд үйл ажиллагаа явуулаагүй байна.

Хайгуулын тусгай зөвшөөрөлтэй ААН-үүд дээрх онуудад үйл ажиллагаа явуулаагүй байгаа талаар аймгийн МХГазар, БОАЖГазраас тодруулахад:

- Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч зарим аж ахуйн нэгжүүдийг орон нутгийн зүгээс ажиллуулахгүй байх ИТХ-ын тогтоол гаргаснаас ажиллаагүй. (Тухайлбал: Хүрээмарал сумын ИТХ-ын хурал хайгуулын ажлыг хориглосон тогтоол гаргасан./2015 онд захиргааны хэргийн шүүхийн давах шатанд хүчингүй болсон/)
- Нутгийн иргэд хөөх, эсэргүүцэх зэргээр ажиллуулдаггүй. (Тухайлбал: Баянбулаг сум хайгуулын тусгай зөвшөөрөлтэй Монгол майнинг энд эксплорэйшн ХХК ажиллуулаагүй)
- Ихэнх тусгай зөвшөөрөл эзэмшигчид нь аймгийн болон сумын ЗДТГ-т 2015 он хүртэл бүртгүүлээгүй үйл ажиллагаагаа эхлээгүй байгаа гэсэн мэдээллийг өгсөн болно.

Аудитад хамрагдсан дээрх хайгуулын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдээс Хонгорхайрхан эрдэнэс ХХК байгаль орчны менежментийн төлөвлөгөө батлуулсан гэх боловч сумын Засаг даргын тамгын газар болон аймгийн БОАЖГ, МХГ-т ирүүлээгүй ба нотлох баримт, материал газар дээрээ байхгүй байна.

Аудитаар Баянговь сумын ЗДТГазарт бүртгэлтэй байгаа хайгуулын талбай болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг шалгахад

Юниверсалкоппер ХХК-ийн нэр дээрх хайгуулын тусгай зөвшөөрөлтэй 8 талбайгаас 2 -д нь төлөвлөгөө батлуулсан байв.

Гэтэл ГАГ-аас ирсэн судалгаанд Юниверсал коппер ХХК-ийн нэр дээрх 6 талбай (9896х, 7814х, 9414х, 5774х, 8965х, 9897х), Гови коулд энд Энержи компаний 1 талбай (11342х), Анион ресорсиз ХХК-ийн 1 талбай (017082х) тусгагдаагүй байна.

Мөн Анион ресорсиз ХХК-ийн 0178082х тоот талбайд 2014 онд байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулж батлуулаагүй байна.

Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Ашигт малтмалын тухай хуулийн 38.1.1. “тусгай зөвшөөрөл авснаас хойш 30 хоногийн дотор байгаль орчны хяналтын алба болон хайгуулын талбай байрших сум, дүүргийн Засаг даргатай зөвшилцөн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө боловсруулах” гэж заасны дагуу байгаль хамгаалах төлөвлөгөөг боловсруулахдаа орон нутгийн захиргаатай зөвшилцөхгүй явж ирсэн байна.

Тухайлбал: Энэ талаар Шинэжсинст сумын Засаг даргаас тодруулахад хайгуулын тусгай зөвшөөрөлтэй ААН-үүдийн байгаль хамгаалах төлөвлөгөөгөө өөрсдөө хийж ирээд батлуулдаг бид нараас санал авдаггүй. Харин бид нар нинжаа нарын эвдсэн газрын нөхөн сэргээхэд санхүүгийн дэмжлэг авч хэрэгжүүлж байсан гэсэн тайлбарыг өгч байна.

Ашиглалт: Аймгийн хэмжээнд нийт 70 ашиглалтын тусгай зөвшөөрөл байгаагаас ГАГ-аас ирүүлсэн судалгаагаар 2013, 2014 онд жил бүр 12 аж ахуйн нэгж байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөө батлуулсан гэсэн мэдээлэл ирсэн ба үүнийг газар дээр нь тулган шалгахад:

2013 оны тулган шалгалт

№	Үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгжийн нэр	Ордны нэр	Ашигт малтмалын төрөл	2013 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө байгаа эсэх /тийм/үгүй/			
				Сумын ЗДТГазарт	Аймгийн БОАЖГазарт	Аймгийн МХГазарт	Уурхайн ажлын талбарт
1	Шижир-аранжин ХХК	Замын хүрэн	Алт	үгүй	үгүй	үгүй	үгүй
2	РЕО ХХК	Хүүшийн ам	Алт	Тийм	Тийм	Тийм	Тийм
3	Нинж-мөрөн ХХК	Манж худаг	Алт	үгүй	үгүй	үгүй	үгүй
4	Андын тэмүүлэл ХХК	Гучин сайр	Алт	Тийм	Тийм	Тийм	Тийм
5	Монголболгаргео ХХК	Мухар эрэг	Алт	Тийм	Тийм	Тийм	Тийм
6	Шинэсансар ХХК	Улаан эрэг /ихэр худаг/	Алт	үгүй	үгүй	үгүй	үгүй
7	Том шижир ХХК	Далт	Алт	Тийм	Тийм	Тийм	Тийм
8	Жи энд юу голд ХХК	Өвөр хөшөөт	Алт	үгүй	үгүй	үгүй	үгүй
9	Гобикоул энд	Хотгор	Нүүрс	Тийм	Тийм	Тийм	Тийм

	энержи ХХК						
10	Баялаг-орд ХХК	Дөвөнт	Нүүрс	Тийм	Тийм	Тийм	Тийм
11	Бритиш майнинг ХХК	Үхэр чулуут	Алт	Тийм	Тийм	Тийм	Тийм
		Онгон улаан-уул	Алт	үгүй	үгүй	үгүй	үгүй
12	Анионресорсиз ХХК	Хөвийн хар	Алт	Тийм	Тийм	Тийм	Тийм

2013 оны Хүснэгтээс харахад Бритиш майнинг ХХК, Анион ресорсиз ХХК-иуд нь ГАГ-аас ирүүлсэн судалгаанд ороогүй байсан бөгөөд аудитад хамрагдсан болно.

2014 оны тулган шалгалт

№	Үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгжийн нэр	Ордны нэр	Ашигт малтмалын төрөл	2013 оны Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөө байгаа эсэх /тийм/үгүй/			
				Сумын ЗДТГазарт	Аймгийн БОАЖГазарт	Аймгийн МХГазарт	Уурхайн ажлын талбарт
1	Шижир-аранжин ХХК	Замын хүрэн	Алт	үгүй	үгүй	үгүй	үгүй
2	РЕО ХХК	Хүүшийн ам	Алт	Тийм	Тийм	Тийм	Тийм
3	Нинж-мөрөн ХХК	Манж худаг	Алт	үгүй	үгүй	үгүй	үгүй
4	Андын тэмүүлэл ХХК	Гучин сайр	Алт	Тийм	Тийм	Тийм	Тийм
5	Монголболгаргео ХХК	Мухар эрэг	Алт	Тийм	Тийм	Тийм	Тийм
6	Шинэсансар ХХК	Улаан эрэг /ихэр худаг/	Алт	үгүй	үгүй	үгүй	үгүй
7	Том шижир ХХК	Далт	Алт	Тийм	Тийм	Тийм	Тийм
8	Жи энд юу голд ХХК	Өвөр хөшөөт	Алт	үгүй	үгүй	үгүй	үгүй
9	Гобикоул энд энерги ХХК	Хотгор	Нүүрс	Тийм	Тийм	Тийм	Тийм
10	Баялаг-орд ХХК	Дөвөнт	Нүүрс	Тийм	Тийм	Тийм	Тийм
11	Спейшл майнз ХХК	Цагаан цахир	Алт	Тийм	Тийм	Тийм	Тийм
12	Бритиш майнинг ХХК	Үхэр чулуут	Алт	Тийм	Тийм	Тийм	Тийм
		Онгон улаан-уул	Алт	үгүй	үгүй	үгүй	үгүй
13	Анионресорсиз ХХК	Хөвийн хар	Алт	Тийм	Тийм	Тийм	Тийм

2014 оны хүснэгтээс харахад Спейшл майнз ХХК, Анионресорсиз ХХК-иуд нь ГАГ-с ирүүлсэн судалгаанд ороогүй байсан бөгөөд аудитад хамрагдсан.

Аудитад оролцсон аймгийн ЗДТГазрын Хөгжлийн бодлогын хэлтэс, МХГ, БОАЖГ-ын холбогдох мэргэжилтнүүд Нинж-мөрөн ХХК, Шинэсансар ХХК, Жи энд юу голд ХХК-иуд нь 2013-2014 онд үйл ажиллагаа явуулаагүй гэсэн мэдээлэл өгсөн бөгөөд аудитын явцад газар дээр нь ажиллахад Шижир-аранжин ХХК, Нинж-мөрөн ХХК-иуд нь үйл ажиллагаа явуулаагүй болох нь нотлогдлоо.

Мөн Бөмбөгөр сумын Улаан эрэг /ихэр худаг/ гэдэг газар ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Шинэсансар ХХК нь сумын ЗДТГазар болон аймгийн МХГ, БОАЖГазарт бүртгүүлээгүй, аудитын объект дээрх шалгалтаар үйл ажиллагаа

явуулаагүй хаана байгаа нь тодорхойгүй байсан ба тухайн компани Баянхонгор аймагт байхгүй болох нь МХГ, БОАЖГ-ын холбогдох мэргэжилтнүүд, Бөмбөгөр сумын байгаль хамгаалагч нарын хэлж байгаагаар нотлогдож байна.

Харин Жи энд юу голд ХХК нь 2013-2014 онд байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулсан гэх боловч холбогдох төрийн байгууллагуудад хүргүүлээгүй, 2014 онд байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөгүй ажилласан зөрчил илэрсэн тул сумын байгаль орчны улсын байцаагчаар хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 40 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний 7680,0 мянган төгрөгийн мөнгөн торгуулийн арга хэмжээ авахуулсан болно.

Аудитын баг Шижир-аранжин ХХК-ний уурхай дээр очиход уурхайн 2015 оны үйл ажиллагаа зогсож, талбайд зөвхөн хамгаалалтын ажилтан байлаа. Тус компанийн 2013-2014 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг МХГ, БОАЖГазраас авах гэсэн боловч тийм мэдээлэл, төлөвлөгөө, тайлан өгөөгүй байна.

Зорилт 1.2: 2013, 2014 онд хайгуулын тусгай зөвшөөрөлтэй ААН-үүд барьцаа хөрөнгийг бүрэн байршуулсан, ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Рео ХХК 10,0 сая, Баялаг орд ХХК 28,9 сая, Андын тэмүүлэл ХХК 7,2 сая, Том шижир ХХК 4,9 сая төгрөгийг дутуу төвлөрүүлсэн байна.

Хайгуул: Хайгуулын тусгай зөвшөөрөлтэй 2013-2014 он үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгжүүдийн хуулийн дагуу төвлөрүүлсэн барьцаа хөрөнгийн төвлөрүүлэлтийг байгаль хамгаалах төлөвлөгөө болон төрийн сангийн дансны хуулгатай тулган шалгалаа.

№	Үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгжийн нэр	Талбайн нэр	БОХ төлөвлөгөөний зардлын дүн /мян.төг/	Хуулийн дагуу байршуулах дүн /мян.төг/	Байршуулсан дүн /мян.төг/ ТС дансаар
2013 он					
1	Эрдэнэмонгол ХХК	Зуун мод	400,0	200,0	500,0
2	Бритиш майнинг ХХК	Их онгон	250,0	125,0	0
3	Гобикоул энд энерги ХХК	Байц	700,0	350,0	0
4	Влэйкмаунт майнинг ХХК	Халзан цахир	0	0	200,0
5	Хонгор хангай эрдэнэс ХХК	Салхитын ам-1	900,0	450,0	450,0
6	Анион ресорсиз ХХК	Хөвийн хар	1400,0	700,0	
7	Юниверсалкоппер ХХК	Өрхөт, хар толгой	6000,0	3000,0	3000,0
				4825,0	4150,0
2014 он					
1	Эрдэнэмонгол ХХК	Зуун мод	0	0	700,0
2	Бритиш майнинг ХХК	Их онгон	0	0	0

3	Гобикоул энд энерги ХХК	Байц	700,0	350,0	650,0
4	Топазстоне ХХК	Хонгор	0	0	100,0
5	Анион ресорсиз ХХК	Хөвийн хар	1200,0	600,0	300,0
6	Централ эша майнинг ХХК				1000,0
				950,0	2750,0

Бритиш майнинг ХХК нь 2013-2014 онд хайгуулийн нөхөн сэргээлтийн барьцааг Шинэжинст суманд төвлөрүүлээгүй байна.

Тайлбар: Энэ талаар гүйцэтгэх захирал Д.Мөнхбат 2011.09.21-нд 1200,0 мянган төгрөгийн нөхөн сэргээлтийн барьцааг Шинэжинст сумын төрийн санд байршуулсан бөгөөд буцаан авалт хийгээгүй тул 2013, 2014 оны нөхөн сэргээлтэд шилжүүлэн тооцсон гэсэн мэдээллийг өгсөн болно. Энэ нь баримтаар нотлогдож байна.

Шинэжинст сумын төрийн санд Влэйкмаунт майнинг ХХК 200,0 мянга, Топазстоне ХХК 100,0 мянга, Централ эша майнинг ХХК 1000,0 мянган төгрөгийн барьцаа хөрөнгө төвлөрүүлсэн боловч газар дээрх шалгалтаар эдгээр компаниудын үйл ажиллагаа явуулсан эсэх болон байгаль хамгаалах төлөвлөгөөтэй холбоотой мэдээлэл сумын ЗДТГазар, аймгийн МХГ, БОАЖГазарт байхгүй байна.

Ашиглалт: Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 2013-2014 онд үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгжүүдийн хуулийн дагуу төвлөрүүлсэн барьцаа хөрөнгийн төвлөрүүлэлтийг Гүйцэтгэлийн аудитын газраас ирүүлсэн мөнгөн хөрөнгийн дансны журнал болон байгаль хамгаалах төлөвлөгөөтэй нь тулган шалгалаа.

№	Үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгжийн нэр	Талбайн нэр	БОХ төлөвлөгөө ний зардлын дүн /мян.төг/	Хуулийн дагуу байршуулах дүн /мян.төг/	Байршуулс ан дүн /мян.төг/	Дутуу байршуулс ан дүн /мян.төг/
2013 он						
1	Шижир-аранжин ХХК	Замын хүрэн	0	0	0	
2	РЕО ХХК	Хүүшийн ам	10000,0	5000,0	0	5000,0
3	Нинж-мөрөн ХХК	Манж худаг	0	0	5000,0	
4	Андын тэмүүлэл ХХК	Гучин сайр	16000,0	8000,0	8000,0	
5	Монголболгаргео ХХК	Мухар эрэг	10380,0	5190,0	0	
6	Шинэсансар ХХК	Улаан эрэг /ихэр худаг/	0	0	0	
7	Том шижир ХХК	Далт	0	0	0	
8	Жи энд юу голд ХХК	Өвөр хөшөөт	0	0	0	
9	Гобикоул энд энерги ХХК	Хотгор	7000,0	3500,0	3500,0	
10	Баялаг-орд ХХК	Дөвөнт	60800,0	30400,0	1415,0	28985,0
14				52090,0	17915,0	
2014 он						
1	Шижир-аранжин ХХК	Замын хүрэн	0	0	0	
2	РЕО ХХК	Хүүшийн ам	10000,0	5000,0	0	5000,0

3	Нинж-мөрөн ХХК	Манж худаг	0	0	0	
4	Андын тэмүүлэл ХХК	Гучин сайр	39100,0	19550,0	12325,0	7225,0
5	Монголболгаргео ХХК	Мухар эрэг	117000,0	58800,0	58000,0	
6	Шинэсансар ХХК	Улаан эрэг /ихэр худаг/	0	0	0	
7	Том шижир ХХК	Далт	42500,0	21250,0	16341,5	4908,5
8	Жи энд юу голд ХХК	Өвөр хөшөөт	43300,0	21650,0	21650,0	
9	Гобикоул энд энерги ХХК	Хотгор	13864,0	6932,0	6932,0	
10	Баялаг-орд ХХК	Дөвөнт	16100,0	8050,0	8850,0	
11	Спейшлмайнз ХХК	Цагаан цахир	47700,0	23850,0	23850,0	
14				165082,0	89948,5	51118,5

Хүснэгтээс үзэхэд 2013, 2014 онд Рео ХХК 10,0 сая, Баялаг-орд ХХК 28,9 сая, Андын тэмүүлэл 7,2 сая, Томшижир ХХК 4,9 сая төгрөг дутуу шилжүүлсэн бөгөөд үүнийг урд онуудад илүү шилжүүлсэн дүнгээс суутган тооцсон гэсэн тайлбарыг өгсөн боловч үүнийг нотлох баримт ирүүлээгүй болно. Аудитын хугацаанд дээрх ААН-үүдтэй эргэн холбогдож мэдээлэл авах гэсэн боловч хариу өгөөгүй болно.

Аудитын явцад 2013-2014 онд төвлөрүүлсэн хайгуулын барьцаа хөрөнгийн зарцуулалтыг шалгахад Шинэжинст сумын ЗДТГазар 2450,0 мянган төгрөгийг нохой устгах, 1000 цэцгийн баярын арга хэмжээ, чацарганын суулгац худалдан авах, байгаль хамгаалах өдөр тэмдэглэх, бараа материал худалдан авах болон нөхөн сэргээлтийн явцын хяналтын шатахуунд зарцуулсан, Баянговь сум 3000,0 мянган төгрөгийг ОНХС-гийн орлогоор бүртгэж зарцуулсан нь БОНХЯ-ны сайдын 2014.01.06-ны А-04 тоот тушаалаар батлагдсан Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журмын 5.5. “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож, тусгай дансанд байршуулсан мөнгөн хөрөнгийг энэхүү журамд зааснаас бусад зориулалтаар ашиглах, зарцуулахыг хориглоно.” заалттай нийцэхгүй байна. Иймд нөхөн сэргээлтийн барьцаа мөнгөн хөрөнгийг Ашигт малтмалын тухай хуулийн 38.1.8. “байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгон холбогдох сум, дүүргийн Засаг даргын нээсэн тусгай дансанд байгаль орчныг хамгаалах арга хэмжээнд шаардагдах тухайн жилийн зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг шилжүүлэх.” гэсэн заалтын дагуу тусгай дансанд байршуулах албан шаардлагыг аймгийн ЗДТГ-ын СТСХ-т хүргүүлэв.

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд байршуулсан мөнгөний буцаан олголт хийгдээгүй, аж ахуй нэгжүүд ч буцааж аваагүй байна.

Тайлбар: Энэ талаар аж ахуйн нэгжүүдээс тодруулахад дараагийн оны нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгөд шилжүүлэн тооцуулсан, хуулиар бол нөхөн сэргээлт хийсэн газраа хүлээлгэн өгөөд авах ёстой боловч барьцааны мөнгийг эргүүлэн өгч, авч байсан удаа байхгүй Төрийн сангийн дансанд тэр чигтэй үлддэг гэсэн тайлбар өгсөн болно.

Мөн барьцааны мөнгөн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхэд хяналт тавьдаг байгууллага байхгүй байна.

Зорилт 1.3: 2013, 2014 онуудад хайгуулын тусгай зөвшөөрөлтэй Бритиш майнинг ХХК, Универсалкоппер ХХК, ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Жи энд юу голд ХХК, Жамп ХХК-иуд байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу нөхөн сэргээлтийг хийгээгүй байна.

Хайгуул: Аудитаар хайгуулын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн 2013-2014 онд хийсэн нөхөн сэргээлтийн ажлыг газар дээр нь холбогдох мэргэжлийн байгууллагуудтай явж шалгахад Бритиш майнинг ХХК нь Шинэжинст сумын “Онгон-Улаан уул”-д хийсэн хайгуулын техникийн нөхөн сэргээлт дутуу, уулын энгэрээр ухсан хайгуулын сувгуудыг дарж булаагүй байв. /зургийг хавсаргав./



Их онгон 12210х



Онгон улаан 14539х


Тайлбар: Нөхөн сэргээлтийг хугацаанд нь бүрэн хийгээгүй талаар тус уурхайн гүйцэтгэх захирал Д.Мөнхбатаас лавлахад геологи хайгуулын судалгааны ажил бүрэн хийгдэж дуусаагүй байгаа бөгөөд төлөвлөж буй хайгуулын ажлын хүрээнд суваг малталтыг үргэлжлүүлэн хийж бүрэн дуусгасны дараа нөхөн сэргээлтийн ажлыг хийнэ гэсэн тайлбарыг албан тоотгоор ирүүлснийг хавсаргав.

Баянговь сумын Хар толгой гэх газарт хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч Универсалкоппер ХХК 2013 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөөр 6,0 сая төгрөгийн нөхөн сэргээлт хийхээр төлөвлөсөн боловч 2015 оны 10-р сарын 05-ны байдлаар нөхөн сэргээлт огт хийгдээгүй байв. Дээрх газарт сумын Засаг дарга, байгаль орчны улсын байцаагч, байгаль хамгаалагч нар 2013-

2015 онуудад ямар ч хяналт тавиагүй, газар дээр нь очиж үзээгүй, тухайн газрын нэрийг ч мэдэхгүй байлаа.



Тэсэлгээ хийгээд нөхөн сэргээлт хийгээгүй талбай



Цооногийн дээр байрлуулсан өргөх тайл



Цооногийн амсар

Хайгуулын талбайд гаргасан олборлолтын цооног

Аудитаар илэрсэн зөрчлөөс үзэхэд Орон нутгийн захиргааны байгууллага Байгаль орчныг хамгаалах тухай хуульд заасан хяналт тавих үүргээ хэрэгжүүлэхгүй байна.

Ашиглалт: Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгжүүдийн 2013, 2014 оны нөхөн сэргээлтийн ажлыг газар дээр нь очиж шалгахад Андын тэмүүлэл ХХК, Том шижир ХХК, Спейшл майнз ХХК, Рео ХХК, Монголболгаргое ХХК, Гоби коулд энерги ХХК, Бритиш майнинг ХХК, Баялаг орд ХХК-иуд 2013-2014 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгэж, аймгийн комисст хүлээлгэн өгсөн байна.

Харин Гурванбулаг сумын “Өвөр хөшөөтийн ам” гэх газар олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа Жи энд юу голд ХХК нь 2013-2014 онд нөхөн сэргээлт хийгээгүй байсан.

Тайлбар: Энэ талаар Гүйцэтгэх захирал Н.Алтанхүүгээс тодруулахад бид 2013 онд ажиллаж чадаагүй, 2014 онд 10-р сар хүртэл ажиллаад хүйтэрсэн тул нөхөн сэргээлт хийж амжаагүй, энэ жил буухаасаа өмнө хийн, гэсэн тайлбарыг хангайн сумдад ажилласан аудитын бүрэлдэхүүнд амаар өгсөн болно.

Мөн аудитад хамтран ажилласан гишүүдийн мэдээллээр Жамп ХХК, туслан гүйцэтгэгч Жигүүр дэл ХХК, Жаргалант сумын ЗДТГазар гурвалсан гэрээ

байгуулан нөхөн сэргээлт хийхээр болсон Жамп компанийн ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Жаргалант сумын “Бөөрөгийн ам” хэмээх талбайд очиж үзэхэд Буман арвижих ХХК олборлолт явуулж байлаа. ГАГ-с ирүүлсэн судалгаа болон аймгийн МХГ, БОАЖГ-ын өгсөн мэдээллээр Жамп ХХК 2013,2014 онуудад байгаль орчны менежментийн төлөвлөгөө хийж батлуулаагүй байна. Энэ нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9.1. “Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилгоор байгаль орчны менежментийн төлөвлөгөөг байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг гүйцэтгэсэн байгууллага боловсруулна.” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Аудитын явцад МХГ-ын улсын байцаагч туслан гүйцэтгэгч “Жигүүр дэл” ХХК-ний үйл ажиллагааг зогсоож, 3 ширхэг алт угаах төхөөрөмжийг лацдаж, 9600,0 мянган, “Буман арвижих” ХХК-ийн алт угаах төхөөрөмжийг лацдаж үйл ажиллагааг нь зогсоон 4800,0 мянган төгрөгийн мөнгөн торгууль тус тус ногдуулав.

Зорилт 2: Эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийх аж ахуйн нэгжийг журмын дагуу сонгон шалгаруулсан боловч журмын 2.2, 8.3 дах заалтыг хэрэгжүүлээгүйгээс нөхөн сэргээлт хийх газрыг газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаагүй, ААН-дээс барьцаа хөрөнгө аваагүй, сонгон шалгаруулалтад шалгарсан ААН-үүд нь өмнөх онд нөхөн сэргээлт хийсэн талбайдаа сумын Засаг даргатай гэрээ байгуулан дахин нөхөн сэргээлт хийх нэрээр олборлолт явуулж байна.

Зорилт 2.1: “Эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийх аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах, үйл ажиллагаанд нь хяналт тавих журам”-д аймгийн ИТХ-ын хуралдааны 2014.05.26-ны өдрийн 9/2 тогтоолоор “...хаягдал, шламж, овоолгыг дахин угааж нөхөн сэргээлтийн ажлаа санхүүжүүлэх” гэж заасан Ашигт малтмалын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3-т “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлохоос бусад тохиолдолд тусгай зөвшөөрөлгүйгээр ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хориглоно.” гэсэн зүйл, заалтыг зөрчсөн байна.

Аймгийн ИТХ-ын 2012.12.26-ны өдрийн хуралдааны 16/1 тогтоолоор батлагдсан “Эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийх аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах, үйл ажиллагаанд нь хяналт тавих журам”-ын “Хаягдал нөөцийг авах замаар ...” гэсэн заалтыг аймгийн ИТХ-ын 2014.05.26-ны өдрийн 9/2 тогтоолоор “Хаягдал, шлам, овоолгыг дахин угааж нөхөн сэргээлтийн ажлаа санхүүжүүлэх” гэж өөрчилжээ.

Энэ нь Ашигт малтмалын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3-т “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлохоос бусад тохиолдолд тусгай зөвшөөрөлгүйгээр ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хориглоно.” гэсэн зүйл, заалтыг зөрчсөн байна.

Энэ асуудлаар мөн Авилгатай тэмцэх газраас “Журмын холбогдох хэсгийг хүчингүй болгуулах тухай” 2014.11.07-ны №01/9428 тоот албан бичгийг аймгийн ИТХ-ын дарга Д.Ширмэнд ирүүлсэн байна.

Үүний дагуу аймгийн ИТХ-ын дарга Д.Ширмэн 2014.12.11-ны өдрийн 1а/418 тоот албан бичгээр Авилгатай тэмцэх газарт “Тус журмын үйлчлэл нь бүхэлдээ 2014.12.31-ний өдөр хүчингүй болох тул зарим хэсгийг хүчингүй болгох шаардлагагүй гэж үзэж байна” гэсэн хариу явуулсан байна. Гэвч энэ журам хүчин төгөлдөр хэвээрээ байна.

Зорилт 2.2: Аймгийн Засаг даргын 2014.04.01-ны 198 тоот захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг нөхөн сэргээлт хийх шаардлагатай эвдэрсэн газрын талбай, цэг солбицлын судалгааг гаргасан боловч түүнд шаардлагатай төсөв, хөрөнгийн тооцоог хийгээгүй байна.

Аймгийн Засаг даргын 2014.04.01-ны 198 тоот захирамжаар ажлын хэсэг байгуулан Баянхонгор аймгийн нутаг дэвсгэрт уул уурхайн компаниуд, иргэдийн үйл ажиллагааны улмаас эвдэрч, эзэн холбогдогч нь тогтоогдох боломжгүй болж орхигдсон, цаашид нөхөн сэргээлт хийх шаардлагатай эвдэрсэн газрын тооллогыг хийж 527,8 га /5278133м2/ байна гэсэн дүн гарган цэг солбицлыг тогтоосон байна. Гэвч Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16.1.1 “нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ, төсөв баталж, биелэлтэд хяналт тавих” заалтын дагуу дээрх талбайг нөхөн сэргээхэд хэдий хэмжээний хөрөнгө, төсөв шаардагдах талаар урьдчилсан төсөв, тооцоо хийгдээгүй байна.

***Тайлбар:** Энэ талаар ажлын хэсгийн ахлагч Х.Бат-оргилоос тодруулахад ажлын хэсэг Аймгийн ИТХ-ын хуралдааны 2014.03.04-ны өдрийн 8/4 тоот тогтоолоор батлагдсан “Эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийх аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулж, үйл ажиллагаанд нь хяналт тавих журам”-ыг хэрэгжүүлэх Засаг даргын захирамжийн дагуу эвдэрсэн газрыг тоолж, цэг солбицлыг тогтоох үүрэгтэй түүнийгээ гүйцэтгэсэн ба түүнд шаардагдах хөрөнгө төсвийн тооцоог гаргаагүй гэсэн тайлбарыг өгсөн болно.*

Зорилт 2.3: Эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийх аж ахуйн нэгжийг журмын дагуу сонгон шалгаруулсан байна.

Аймгийн ЗДТГазар нь аймгийн ИТХ-ын хуралдааны 2014.03.04-ны өдрийн 8/4 тоот тогтоолоор батлагдсан “Эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийх аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулж, үйл ажиллагаанд нь хяналт тавих журам”-ын дагуу Баян-Овоо, Бөмбөгөр, Бууцагаан, Заг, Жаргалант, Галуут гэсэн 6 сумын нутгийг хамарсан 301,3 га газрыг байрлалаас нь хамааруулан 10 багц газар болгон хуваан нөхөн сэргээлт хийх төсөл сонгон шалгаруулалтыг 2014 оны 04.16 - 05.06-ны хооронд зохион байгуулсан байна.

Аймгийн ИТХ-ын хуралдааны 2014.05.26-ны өдрийн 9/2 тоот тогтоолоор 2014.03.04-ны өдрийн 8/4 тоот тогтоолыг хүчингүй болгон “Эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийх аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулж, үйл ажиллагаанд нь хяналт тавих журам”-ын үндэслэлд өөрчлөлт оруулан дахин баталсан байна. Мөн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014.05.26-ны өдрийн 77 тоот тогтоолоор эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийх ААН-ийг сонгон шалгаруулах 6 комиссыг тус бүр 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр баталсан байна.

Эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийхээр 26 аж ахуйн нэгжээс материал ирүүлснээс сонгон шалгаруулалт явуулах комисс 12 аж ахуйн нэгжийг шалгаруулсан бөгөөд тус ААН-үүд нь 2014 оны 06-р сард аймгийн Засаг даргатай гэрээ байгуулсан байна.

Зорилт 2.4: Сонгон шалгаруулалтад шалгарсан ААН-үүд өмнөх онд нөхөн сэргээлт хийсэн талбайдаа сумын Засаг даргатай гэрээ байгуулан дахин нөхөн сэргээлт хийж байгаа гэсэн нэрээр олборлолт явуулсан нь Ашигт малтмалын тухай хуулийн 7.3. “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлохоос бусад тохиолдолд тусгай зөвшөөрөлгүйгээр ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хориглоно. ...” гэсэн заалтыг зөрчиж байна.

Тус журмын 2.2-т “...аймаг, сумдын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулна” гэж заасны дагуу сумд 2014 оны газар

зохион байгуулалтын төлөвлөгөөндөө өөрчлөлт оруулан нэмж батлаагүй, 8.3-т “Нөхөн сэргээлт хийх аж ахуйн нэгж нь нэг га тутамд 5 сая төгрөг буюу түүнээс дээш барьцааг байршуулах бөгөөд компани гэрээний үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүй бол үл маргах журмаар барьцаа төлбөрөөр гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулна.” гэсэн заалтын дагуу гэрээ байгуулсан 12 аж ахуйн нэгж нийт 1209,0 сая төгрөгийн барьцаа хөрөнгө байршуулаагүй байна.

Сонгон шалгаруулалтад тэнцэж гэрээ хийсэн ААН-үүдийн гэрээний хугацаа 2014 оны 12-р сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тул барьцаа хөрөнгийг нөхөн төлүүлэх боломжгүй болсон бөгөөд гэрээний үүргээ биелүүлээгүй доорх ААН-үүдийн гүйцэтгэх нөхөн сэргээлтийн ажлыг хууль, журамд заасан мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх боломжгүй болсон байна.

Дээрх журамд заасны дагуу нөхөн сэргээлтийн хийсэн ААН-үүд нь нөхөн сэргээлт хийсэн газрыг хүлээлгэн өгөөгүй, тайлант ондоо багтаан гэрээгээ дүгнүүлээгүй байна.

Аудитын хугацаанд дээрх журмын дагуу нөхөн сэргээлт хийсэн газруудаас түүвэрлэн шалгав. Үүнд:

1. Баян-овоо сумын Алтан ус, Ташаа гэх газарт хийсэн нөхөн сэргээлтийг 2015.10.07-нд газар дээр нь шалгахад дараах зөрчил илэрсэн болно. Үүнд:

- “Хөх бүрдний эх” ХХК гэрээнд заасан хугацаанд нөхөн сэргээлтийг бүрэн хийгээгүй, аймгаас томилогдсон комисс хүлээн аваагүй байхад Баян-Овоо сумтай гэрээ байгуулсан нэрээр тухайн талбайд 2015 онд дахин олборлолтын үйл ажиллагаа явуулж байсан. Иймд тус компанийн холбогдох албан тушаалтан болон аж ахуй нэгжид хуулийн дагуу хариуцлага тооцож ажиллах зөвлөмж өгөв.



- “Сидар” ХХК нөхөн сэргээлтийн ажлыг дутуу хийсэн, аймгийн комисс хүлээж аваагүй гэсэн үндэслэлээр уг талбайд 2015 онд дахин олборлолтын үйл ажиллагаа явуулж нуур тунгаагуур бэлтгэсэн байна.



- “Арвайн гэгээ” ХХК-ний 2014 онд аймгийн Засаг даргатай гэрээ байгуулж нөхөн сэргээлт хийж аймгийн комисст актаар хүлээлгэн өгсөн талбайд 2015 онд “Баянхонгор тамгат” ХХК Баян-Овоо сумын Засаг даргатай нөхөн сэргээлт хийх гэрээ байгуулж , олборлолтын үйл ажиллагаа явуулж байна.



- “Цастын салхи” ХХК 2014 оны гэрээнд техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийхээр заасан боловч зөвхөн техникийн нөхөн сэргээлтийг дутуу хийж, “Сидар” ХХК-тай тохиролцож хийлгэх нэрээр зарим газрыг үлдээсэн байна.



2. Жаргалант сумын Бөөрөг гэх газарт нөхөн сэргээлт хийхээр гэрээ байгуулсан “Буянцэцэн” ХХК нь аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээнд заасан талбайд ХАМО иргэд үйл ажиллагаа явуулж байгаа тул сумын Засаг

даргатай гэрээ байгуулан өөр талбайд нөхөн сэргээлтийг хийхдээ Ашигт малтмалын тухай хуулийн 7.3. “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлохоос бусад тохиолдолд **тусгай зөвшөөрөлгүйгээр** ашигт малтмал эрэх, хайх, **ашиглахыг хориглоно. ...**” гэсэн заалтыг зөрчин олборлолтын үйл ажиллагаа явуулсан байсан тул МХГ-ын байцаагч 9600,0 мянган төгрөгийн торгууль ногдуулав.

Мөн Жаргалант сумын Мандалын Анаг нэртэй газарт тусгай зөвшөөрөлгүйгээр нөхөн сэргээлт нэрийн дор олборлолтын үйл ажиллагаа явуулж байсан “Буян арвижих тал” ХХК-д 9600,0 мянган төгрөгийн торгууль ногдуулсан.

Аудитад хамрагдсан дээрх ААН-д нь аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор батлагдсан журмын 2-т “...хаягдал, шлам, овоолгыг дахин угааж нөхөн сэргээлтийн ажлаа санхүүжүүлэх замаар нөхөн сэргээлт хийх...” гэсэн заалтыг зөрчиж эвдэрсэн талбайд олборлолт явуулж байгаа нь Ашигт малтмалын тухай хуулийн 7.3. “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлохоос бусад тохиолдолд **тусгай зөвшөөрөлгүйгээр** ашигт малтмал эрэх, хайх, **ашиглахыг хориглоно. ...**” гэсэн заалтыг зөрчиж байсан тул МХГ-ын байцаагч дээрх зөрчил гаргасан ААН-үүдийн алт угаах төхөөрөмжийг лацдаж, үйл ажиллагааг зогсоох арга хэмжээ авч ажилласан.

Аудитын ажлын хэсэг хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй ААН-үүдийн нөхөн сэргээлтийг газар дээр нь шалгахад явцад Өлзийт сумын Ар өнц хэмээх газар Цастын салхи ХХК Өлзийт сумын Засаг даргатай 2015 онд гэрээ хийсэн боловч нөхөн сэргээлт хийлгүй “Мэндийн түшээ” ХХК, “Хөх тэнгэрийн зам” ХХК-иудийг тус газар оруулан олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа зөрчлийг илүүлсэн. Ашигт малтмалын тухай хуулийн 7.3. “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлохоос бусад тохиолдолд **тусгай зөвшөөрөлгүйгээр** ашигт малтмал эрэх, хайх, **ашиглахыг хориглоно. ...**” гэсэн заалтыг зөрчсөн дээрх ААН-үүдэд Өлзийт сумын байгаль орчны улсын байцаагч харицулага тооцож боломжгүйгээ бичгээр мэдэгдсэн тул аймгийн МХГазарт ААН-үүдийг холбогдох хуулийн дагуу шалгаж арга хэмжээ тооцож ажиллах зөвлөмж өгөв. /зургийг хавсаргав./



Овоолго



Олборлолт



Алт угаах төхөөрөмж


Зорилт 3: Уул уурхайн хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй ААН-үүдээс 2013, 2014 онд 687,4 сая төгрөг, эвдэрсэн газрын нөхөн сэргээлт хийсэн ААН-үүдээс 2014 онд 1921,0 сая төгрөгийн хандивын хөрөнгө оруулалт хийгдсэнийг бүртгэл тайланд тусгасан боловч Төсвийн тухай хуулийн 25.8-д заасны дагуу мэдээлээгүй байна.

Зорилт 3.1: Орон нутгийн төсвийн байгууллагууд нь Төсвийн тухай хууль заасны дагуу хандив авсан талаарх мэдээ тайланг аймгийн Төрийн санд гарган өгөөгүй байна.

Аймаг, сумын төсвийн байгууллагууд нь уул уурхайн үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдээс 2013, 2014 онд өгсөн тусламж, хандивын талаарх мэдээ тайланг аймгийн Төрийн санд Төсвийн тухай хуулийн 25.8-д “Төсвийн ерөнхийлөн захирагч тусламж, хандив авсан тухай баримтын хувийг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн санд нэг сарын дотор хүргүүлнэ.” гэж заасны дагуу аймгийн төрийн санд өгөөгүй байна.

Зорилт 3.2: Уул уурхайн хандиваар бий болсон хөрөнгийг бүртгэлд тусгасан боловч олон нийтэд тайлагнаж мэдээлээгүй байна.

Орон нутгийн захиргааны байгууллага уул уурхайн аж ахуйн нэгжүүдтэй байгуулсан гэрээнд “Орон нутагт дэд бүтцийг сайжруулах, амьжиргааг дээшлүүлэх, боловсрол эрүүл мэндийг дэмжих зорилгоор хандив өгч болно.” гэсэн заалт оруулсан нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17.1 дэх “Албан тушаалтан, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага нийтийн хэрэгцээнд зориулан иргэн, хуулийн этгээдээс бэлэг, бусад санхүүгийн туслалцааг авах, хүсэхийг хориглоно.” гэсэн заалттай нийцэхгүй байна.



Уул уурхайн компаниудаас авсан хандив: Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй ААН-ээс 2013 онд 15 компани 15 суманд 510,3 сая төгрөгийг, 2014 онд 13 компани 6 суманд 177,1 сая төгрөгийн хандив, хөрөнгө оруулалт өгсөн байна.

Аудитаар уул уурхайн компаниудын өгсөн хандив, хөрөнгө оруулалт, түүний зориулалт, зарцуулалтын байдлыг судалж үзэхэд:

Баянхонгор аймагт: 2013 онд Монголболгаргео ХХК-иас ОНХС-д 50,0 сая, 2014 онд Ламын гэгээний нийгмийн хөгжил ТББ-д 100,0 сая төгрөг, Баялаг орд ХХК Ламын гэгээний нийгмийн хөгжил ТББ-д 10,0 сая төгрөг хандивласан байна.

Аймгийн ОНХС-нд 2013 онд уул уурхайн 9 ААН-ээс 336,0 сая, 2014 он 4 ААН-ээс 120,0 сая төгрөгийн хандив өгсөн байна.

Баян-Овоо сум: 2013 онд Баяжмал алт ХХК-иас ЭМТ-ийн их засварт 31,1 сая төгрөг, Сантавиач ХХК-иас сургуулийн гал тогооны тоног төхөөрөмж авахад 5,0 сая, 2014 онд Спейшл майнз ХХК-иас сургуулийн гэрлийн монтаж хийхэд 9,8 сая төгрөгийн хандив өгсөн байна.

Бөмбөгөр сум: 2013 онд Томшижир ХХК-иас сумын 90 жилийн ойн ном хэвлүүлэх зардалд 10,0 сая төгрөг (хэвлэлийн компанид шилжүүлсэн), Ай эн ди ХХК-иас сумын 90 жилийн ойн баяр наадам тэмдэглэх зардалд 10,0 сая төгрөгийн хандив авч зарцуулсан.

Галуут: 2013 онд наадмын талбай тохижуулахад Сайенс элементис ХХК 10,0 сая төгрөг, Рео ХХК 10,0 сая төгрөг, Жамп ХХК ногоон байгууламж байгуулахад 6,0 сая төгрөг, Мондулаан ХХК гүн өрмийн худаг гаргахад 10,0 сая төгрөг, Нинжмөрөн ХХК сумын 90 жилийн ойн хандивт 5,0 сая төгрөг, Зоос гоулд ХХК гандангийн засварт 2,0 сая төгрөг, Шижир аранжин ХХК гудамж талбайн хог хаягдал цэвэрлэхэд 10,0 сая төгрөг, 2014 онд Монголболгаргео ХХК сумын ИТХ-ын автомашин худалдан авахад 10,0 сая төгрөгийн хандив өгсөн байна.

Баян-Өндөр сум: 2013 онд Баян-Өндөр сумын 90 жилийн ойн арга хэмжээнд Гоби коул энд энерги ХХК 4,0 сая төгрөг, Эрдэнэ монгол ХХК 10,0 сая төгрөг, Хул морьт майнинг ХХК 10,0 сая төгрөг, Эпидот ХХК 1,0 сая төгрөг, 2014 онд Сургууль, Цэцэрлэг, ЭМТ-ийн тохижилтод Эпидот ХХК 15,0 сая төгрөг, Идрэн 4-р багийн тэмцээнд Эрдэнэ монгол ХХК 3,0 сая төгрөг хандивласан байна.

Шинэжинст сум: 2013 онд Эрдэнэ монгол ХХК оюутны сургалтын төлбөрт 2,0 сая төгрөг, сумын төвийн дизель асаахад 8,0 сая төгрөгийн түлш, сумын иргэдэд тусламж, эмчилгээний зардалд 7,6 сая төгрөг, Цэцэрлэгийн тоглоомын талбайд 3,5 сая төгрөгийн гулсуур, ЭМТ-д намрын спартакиадад 4,7 сая төгрөг, 2014 онд намрын спартакиадад 3,5 сая төгрөг хандивласан байна.

Баянлиг: 2014 онд Сургуулийн 70 жилийн ойд Баяжтату ХХК 5,0 сая төгрөгийн хандив өгсөн.

Баянговь: Универсалкоппер ХХК 2013 онд ахмадуудад зориулж 14,4 сая төгрөгийн үнэтэй сандвичин барилга хандивласан.

Өлзийт сум: 2014 онд Сумын сургуулийн 90 жилийн ойд түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглагч Ихбогд зам ХХК 5,0 сая төгрөг, Хаш-гоёо ХХК 2,9 сая төгрөг, Хөх бүрдний эх ХХК 3,0 сая төгрөг хандивласан байна.



Нөхөн сэргээлтийн гэрээгээр өгсөн хандив: Аймгийн ИТХ-ын 2014.05.26-ны өдрийн 9/2 тоот тогтоолоор батлагдсан “Эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийх аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулж, үйл ажиллагаанд нь хяналт тавих журам”-ын дагуу аймгийн Засаг даргатай гэрээ байгуулсан 12 аж ахуйн нэгж аймгийн төвд 1688,0 сая төгрөг бүтээн байгуулалт, 5 суманд 233,0 сая төгрөгийн хандив, хөрөнгө оруулалт өгсөн байна.

Баянхонгор аймгийн төвд: Хөх бүрдний эх ХХК 190,0 сая, Арвайн гэгээ ХХК 160,0 сая, Баянхонгор тамгат ХХК 180,0 сая, Цастын салхи ХХК 240,0 сая, Сидар ХХК 190 сая, Хөх тэнгэрийн зам ХХК 80,0 сая, Тэргүүн хонгор ХХК 30,0 сая, Дэнхээлжин 220,0 сая, Буянцэцэн ХХК 240,0 сая, Нийгмийн хариуцлагатай уул уурхай ТББ 140,0 сая, Баянтойром ХХК 18,0 сая төгрөг нийт 1688,0 сая төгрөгийн хандив өгснийг Төв зам дагуу услалтын системийн ажилд 392,6 сая, Эрдэнэмандал хайрханы тохижилтонд 540,0 сая, Гандангийн талбайн тохижилтонд 500,0 сая, аймгийн төвийн авто замын ажилд 75,4 сая, Төв талбай, ХДТеатрт лед дэлгэц авах, суурилуулахад 180,0 сая төгрөгийн ажлуудын санхүүжилтэнд гүйцэтгэгч компаниудад хандивлагч ААН-үүд шууд шилжүүлсэн байна.



Дээрх ААН-үүдээс өгсөн хандивын хэмжээг аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтсээс авсан бөгөөд холбогдох ААН-үүд хандивын талаар албан ёсны мэдээлэл өгөхөөс татгалзсан тул нэг талын мэдээллээр тайланд тусгасан болно.

Тус хөрөнгийг орлогод бүрэн авсан эсэхийг шалгахад аймгийн төвийн авто замын ажил бүрэн хийгдэж дуусаагүй гэсэн шалтгаанаар бүртгэлд тусгаагүй бусад хөрөнгийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014.11.17-ны 137 тоот тогтоолоор орон нутгийн өмчид бүртгэсэн байна.


Заг сум: 2014 онд сумын 90 жилийн ойд Дэнхээлжин ХХК 30,0 сая төгрөгийн хандив өгсөн.

Жаргалант сум: 2014 онд Буянцэцэн ХХК 3-р багийн соёлын төв барихад 33,0 сая, 10 айл малжуулахад 12,0 сая төгрөгийг хандивласан.

Галуут сум: 2014 онд Арвайн гэгээ ХХК амьжиргааны төвшин доогуур 2 иргэнд 3,0 сая төгрөгийн өртөг бүхий 4 ханатай гэр өгсөн.

Бууцагаан сум: 2014 онд Сумын 90 жилийн ойн арга хэмжээнд Тэргүүн хонгор ХХК 10,0 сая, иргэн Н.Алтантуул 10,0 сая, иргэн Эрдэнэ-очир 5,0 сая төгрөгийн хандив өгсөн.

Баян-Овоо сум: 2014 онд Баянхонгор тамгат ХХК 30,0 сая, Арвайн гэгээ ХХК 40,0 сая, Хөх бүрдний эх ХХК 2-р багийн төвийн барилгыг 60,0 сая төгрөгөөр барьж хандивласан байна.



Зорилт 4: Тусгай зөвшөөрөл бүхий ААН-үүд гэрээгээр хүлээсэн үүрэг, хяналт шалгалтын байгууллагаас гаргасан шийдвэрийг биелүүлээгүй, орон нутгийн болон холбогдох мэргэжлийн байгууллага гаргасан шийдвэрийнхээ

хэрэгжилтийг тооцохгүй байгаагаас хяналт шалгалтын ажлын үр дүн бүрэн гарахгүй байна.

Аудитын хугацаанд уул уурхайн нөхөн сэргээлтийн үйл ажиллагаанд орон нутгийн захиргааны болон мэргэжлийн байгууллага, тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд хуулиар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгааг шалгахад:

Аймгийн БОАЖГазар нь нөхөн сэргээлт хүлээн авах комиссыг ахлан тогтмол ажиллаж уул уурхайн ААН-ийн ирсэн хүсэлтийн дагуу нөхөн сэргээлтийг MNS 5917:2008 стандартын шаардлагын дагуу хүлээн авч, шаардлага хангаагүйд нь зөвлөмж өгч ажилласан боловч Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 15.7-д заасан “байгаль орчныг хамгаалах, түүний баялгийн нөөцийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар төрийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагад аргачилсан туслалцаа, санхүүгийн дэмжлэг үзүүлэх” эрхээ хэрэгжүүлээгүй байна.

Аймгийн МХГ-аас 2013 оны 10-р сар, 2014 оны 07-р саруудад уул уурхайн нөхөн сэргээлтийн ажилд хяналт шалгалтыг явуулсан ба 2013 онд шалгалтад хамрагдсан уурхайнууд нь MNS 5918:2008 стандартын дагуу тарих ургамал, үрийн төрөл, тарих хугацааг зөв сонгон тариалаагүйгээс үрийн өсөлт ургалт хангалтгүй, 2013, 2014 онд “Бадамлах очир” ХХК байгаль орчны төлөвлөгөө батлуулаагүй, “Том шижир” ХХК байгаль орчны төлөвлөгөөг хангалтгүй биелүүлсэн, компаниуд хог хаягдлын түр цэгийг сумын Засаг даргаар тогтоолгоогүй зэрэг зөрчил илэрсэн гэсэн тайлан гаргасан байна.

Аймгийн МХГ-аас 2015.07.07-нд нөхөн сэргээлтийн ажил хийх нэрээр олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа “Сидар” ХХК, “Хөх бүрдний эх” ХХК, “Буянцэцэн” ХХК, “Баянхонгор тамгат” ХХК, “Цастын салхи” ХХК-иудын үйл ажиллагааг зогсоох акт гаргасан боловч дээрх ААН-үүд актыг хэрэгжүүлээгүй байна. Имйд МХГ-аас зөрчлийг дахин давтан гаргаж байгаа дээрх ААН-ийг шалгуулахаар 2015.09.13-ны өдөр аймгийн Цагдаагийн газарт хандсан байна.

Цагдаагийн газраас дээрх зөрчлийг хэрхэн шийдвэрлэсэн талаар тодруулахад:

Тодруулга: Нөхөн сэргээлт нэрийн дор хууль бусаар ашигт малтмал олборлох үйл ажиллагаа явуулж байна гэх гомдол мэдээллийг хүлээн авч Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 172 дугаар зүйлд заасны дагуу хойшлуулишгүй ажиллагааг явуулаад хохирлын үнэлгээ гаргах боломжгүй байсан учир эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж шийдвэрлэсэн гэсэн мэдээллийг мөрдөн байцаагч, цагдаагийн ахлах дэслэгч Б.Баттөмөр өгсөн болно.

МХГ-аас Баян-Овоо, Жаргалант, Өлзийт сумдын ИТХ-ын Тэргүүлэгчдийн гаргасан нөхөн сэргээлт хийх тогтоолуудыг хүчингүй болгуулах нэхэмжлэлийг 2015.10.12-ны өдөр захиргааны хэргийн шүүхэд өгсөн байна.

Аудитын явцаас үзэхэд уул уурхайн компаниуд нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөний эх хувийг уурхайн ажлын байранд байлгадаггүй, мэргэжлийн /МХГ, БОАЖГ/ байгууллагын шаардлагыг биелүүлээгүй, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг цаг хугацаанд нь хэрэгжүүлэхгүй байна.

Тухайлбал: “Жи энд юу голд” ХХК, “Жамп” ХХК, “Бритиш майнинг” ХХК, “Юниверсалкоппер” ХХК-уудын байгаль орчны менежментийн төлөвлөгөө уурхайн ажлын байранд болон сумын ЗДТГазар байхгүй, 2013, 2014 оны нөхөн сэргээлтийг хийгээгүй байна.

Мөн ашигт малтмалын тухай хуулийн 7.3. “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлохоос бусад тохиолдолд **тусгай зөвшөөрөлгүйгээр** ашигт малтмал эрэх, хайх, **ашиглахыг хориглоно.** ...” гэсэн заалтыг зөрчсөн нөхөн сэргээлтийн гэрээ байгуулсан ААН-үүдийн үйл ажиллагааг зогсоох зорилгоор угаах төхөөрөмжийг нь лацадсан аймгийн МХГ-ын шийдвэрийг үл хүндэтгэн, лацыг авч үйл ажиллагаа явуулсаар байна.

Тухайлбал: “Буян арвижих” ХХК, “Баянхонгор тамгат” ХХК, “Хөх бүрдний эх” ХХК, “Буянцэцэн” ХХК, “Сидар” ХХК, “Буман арвижих” ХХК-ууд нь 2015.10.07-нд тавьсан лацыг хөндөж үйл ажиллагаа явуулж байна.

Бичил уурхайн үйл ажиллагаа явуулж буй нөхөрлөлүүд нь нөхөн сэргээлтийн ажлыг тодорхой хэмжээнд хийн суманд хүлээлгэн өгч байгаа боловч тухайн газрын хамгаалалт хангалтгүйгээс өөр нөхөрлөл тухайн газрыг дахин ухаж байгаа нь нөхөн сэргээлтийг үр дүнгүй болгож байна.

Монгол улсын Засгийн газрын 2010.12.01-ны өдрийн 308 дугаар тогтоолоор баталсан “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ын дагуу 2015.10.13-ны байдлаар Баян-Овоо, Галуут, Жаргалант, Бөмбөгөр сумдад 6 Төрийн бус байгууллагын 52 нөхөрлөлд 371 иргэн бичил уурхайн үйл ажиллагаа явуулж байна.

Баян-Овоо сумын Цагаан цахир гэх газар тусгай зөвшөөрөл эзэмшигч Спейшл майнз ХХК, Баян-Овоо сумын Засаг дарга, “ХАМОДХ” Төрийн бус байгууллага /23 нөхөрлөлийн 72 иргэн/ хооронд дээрх журамд заасны дагуу гурвалсан гэрээ байгуулан ажиллаж байгаа ба бусад сумдын нөхөрлөлүүд хууль бусаар үйл ажиллагаа явуулж байна.

Сумдын Засаг дарга нар дээрх журмын 3.7-д *“Байгаль орчныг нөхөн сэргээх талаар нөхөрлөлөөс авсан арга хэмжээ, хийсэн ажлын тайланг авч, газар дээр нь шалган, геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас баталсан зааврын дагуу нөхөн сэргээлтийн ажлыг хийлгэсний үндсэн дээр хүлээн авч, энэ тухай мэдээллийг аймаг, нийслэлийн мэргэжлийн хяналтын байгууллагад жилд 1 удаа хүргүүлж байх.”* гэж заасан байхад энэ тухай мэдээллийг аймгийн МХГазарт нэг ч удаа хүргүүлээгүй байна.

Тодруулга: Энэ талаар аймгийн БОАЖГазраас тодруулахад тус журамд зөвхөн сумын эрх үүргийг зааж өгсөн, аймгаас ямар нэгэн оролцоо байхгүй, сумдын ИТХ-аас Бичил уурхайн зориулалтаар орон нутгийн тусгай хэрэгцээнд авахаар сонгож, солбицлыг тогтоосон газрын талаар дүгнэлт гаргуулахаар Геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад явуулахад дүгнэлтийг гаргаж өгөхөөс татгалзсан хариу өгдөг. Гэвч сумдын ИТХурал дээрх журмыг үндэслэл болгон тогтоол гаргаж үүний дагуу Засаг дарга нөхөрлөлүүдтэй гэрээ байгуулан ажилладаг гэсэн тайлбарыг өгсөн болно.

Аймгийн БОАЖГазраас өгсөн 2015.10.13-ны мэдээгээр бичил уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа нөхөрлөлүүд нь 2014 онд Жаргалант суманд 6 га, Галуут суманд 3,6 га, Баян-Овоо суманд 5,4 га, Бөмбөгөр суманд 1 га талбайд тус бүр техникийн нөхөн сэргээлт хийсэн байна.



Гэвч аймгийн МХГ-ын хяналт шалгалтаар нөхөн сэргээлт хийсэн газарт хэдэн сар эсвэл жилийн дараа өөр нэг нөхөрлөл дахин ухаж, нөхөн сэргээлтийн ажлыг үр дүнгүй болгож байгаа зөрчил илэрсэн байна.

Тухайлбал: 2014 он Бөмбөгөр сумын нөхөрлөлүүд Буйлсан гэх газарт, Жаргалант сумын нөхөрлөлүүд Бөөрөг гэх газрын баруун салаанд нөхөн сэргээлтийг хийхчээд эргүүлэн ухсан байна.

Аудитаар зөрчил гаргасан ААН-үүдэд аймгийн МХГ-ын улсын байцаагч 41,2 сая төгрөгийн торгууль ногдуулж, 5450,0 мянган төгрөгийн зөрчил илрүүлж албан шаардлага өгөв.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг өгч байна.

1. Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 2013-2014 онд үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгжүүд нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөг холбогдох газраар батлуулсан боловч зарим ААН-үүд орон нутгийн төрийн захиргааны байгууллагуудад төлөвлөгөөг хүргүүлээгүй, Рео ХХК 10,0 сая, Баялаг орд ХХК 28,9 сая, Андын тэмүүлэл ХХК 7,2 сая, Том шижир ХХК 4,9 сая төгрөгийн нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийг дутуу төвлөрүүлжээ.

2. 2013, 2014 онуудад хайгуулын тусгай зөвшөөрөлтэй Бритиш майнинг ХХК, Универсалкоппер ХХК, ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Жи энд юу голд ХХК, Жамп ХХК-иуд байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу нөхөн сэргээлтийн ажлыг хийгээгүй байна.

3. “Эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийх аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах, үйл ажиллагаанд нь хяналт тавих журам”-д аймгийн ИТХ-ын хуралдааны 2014.05.26-ны өдрийн 9/2 тогтоолоор “...хаягдал, шлам, овоолгыг дахин угааж нөхөн сэргээлтийн ажлаа санхүүжүүлэх” гэж заасан нь Ашигт малтмалын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3-т “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлохоос бусад тохиолдолд тусгай зөвшөөрөлгүйгээр ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хориглоно.” гэсэн зүйл, заалтыг зөрчсөн байна.

4. Аймгийн Засаг даргын 2014.04.01-ны 198 тоот захирамжаар нөхөн сэргээлт шаардлагатай эвдэрсэн газрын тооллого хийсэн боловч Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16.1.1 “нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ, төсөв баталж, биелэлтэд хяналт тавих” заалтын дагуу шаардагдах төсвийн тооцоог хийгээгүй байна.

5. Эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийх журмын 8.3-т “Нөхөн сэргээлт хийх аж ахуйн нэгж нь нэг га тутамд 5 сая төгрөг буюу түүнээс дээш барьцааг байршуулах ...” гэж заасан байхад 12 ААН-ээс 1209,0 сая төгрөгийн барьцаа хөрөнгө авалгүй гэрээ хийснээс гэрээний үүргээ биелүүлээгүй ААН-үүдийн гүйцэтгэх нөхөн сэргээлтийн ажлыг хууль, журамд заасан мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх боломжгүй болсон байна.

6. Сонгон шалгаруулалтад шалгарсан ААН-үүд нь өмнөх онд нөхөн сэргээлт хийсэн талбайдаа сумын Засаг даргатай гэрээ байгуулан дахин нөхөн сэргээлт хийж байгаа гэсэн нэрээр олборлолт явуулсан нь Ашигт малтмалын тухай хуулийн 7.3. “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлохоос бусад тохиолдолд тусгай зөвшөөрөлгүйгээр ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хориглоно. ...” гэсэн заалтыг зөрчсөн ба 2014 онд аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээгээ дүгнүүлээгүй байна.

7. Төрийн болон орон нутгийн төсвийн байгууллагууд нь Төсвийн тухай хуульд заасны дагуу хандив авсан талаарх мэдээ тайланг аймгийн Төрийн санд өгөөгүй байна.

8. Тусгай зөвшөөрөл бүхий ААН-үүд гэрээгээр хүлээсэн үүрэг, хяналт шалгалтын байгууллагаас гаргасан шийдвэрийг биелүүлээгүй, орон нутгийн болон холбогдох мэргэжлийн байгууллага гаргасан шийдвэрийнхээ хэрэгжилтийг тооцохгүй байгаагаас хяналт шалгалтын ажлын үр дүн бүрэн гарахгүй байна.

9. Бичил уурхайн үйл ажиллагаа явуулж буй нөхөрлөлүүд нь нөхөн сэргээлтийг тодорхой хэмжээнд хийн суманд хүлээлгэн өгч байгаа боловч нөхөрлөлүүд тухайн газраа дахин ухаж байгаа нь нөхөн сэргээлтийг үр дүнгүй болгож байна.

Тайлбар:Тайлангийн төсөлтэй танилцаад аймгийн Засаг даргаас ирүүлсэн албан тоотод аймгийн ИТХ-ын 2012.12.26-ны өдрийн хуралдааны 16/1 тогтоолоор батлагдсан “Эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийх аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах, үйл ажиллагаанд нь хяналт тавих журам” нь 2014.12.31-нээр бүхэлдээ хүчингүй болсон гэсэн тайлбарыг ирүүлсэн бөгөөд хүчингүй болгосон тогтоолоо ирүүлэхийг шаардахад тийм тогтоолыг ирүүлээгүй болно. Үүний талаар аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга Б.Гантулгаас тодруулахад бид хүчингүй болгох заалт оруулсан, харин ИТХ-ын хуралдаанаар журмыг батлахдаа тэр заалтыг нь хасаж баталсан, 2015 онд аймгийн ЗДТГ-аас дээрх журмыг хэрэгжүүлээгүй гэсэн тайлбарыг өгсөн.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ё.СУГАРРАГЧАА

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүгнэлтэд үндэслэн доорхи албан тушаалтнуудад дараах зөвлөмжийг өгч байна.

Аймгийн ИТХ-ын дарга Д.Ширмэн танаа

- “Эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийх аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах, үйл ажиллагаанд нь хяналт тавих журам”-д аймгийн ИТХ-ын хуралдааны 2014.05.26-ны өдрийн 9/2 тогтоолоор “...**хаягдал, шлам, овоолгыг дахин угааж нөхөн сэргээлтийн ажлаа санхүүжүүлэх**” гэж заасан нь Ашигт малтмалын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3-т “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлохоос бусад тохиолдолд тусгай зөвшөөрөлгүйгээр ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хориглоно.” гэсэн зүйл, заалтыг зөрчсөн тухай Авлигатай тэмцэх газрын “Журмын холбогдох хэсгийг хүчингүй болгуулах тухай” 2014. 11. 07-ны 01/9428 тоот албан бичгээр өгсөн үүргийг биелүүлэх.
- Ашигт малтмалын тухай хуулийн 12.1.3. “байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хүн амын эрүүл мэндийг хамгаалах болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн талаар хүлээсэн үүргээ тусгай зөвшөөрөл эзэмшигч хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих” заасны дагуу хяналт тавьж ажиллах.

Аймгийн Засаг дарга Д.Жаргалсайхан танаа

- Уул уурхайн тусгай зөвшөөрөл эзэмшигч, төсөл хэрэгжүүлэгч ААН-үүдийн үйл ажиллагаанд Ашигт малтмалын тухай хуулийн 12.1.3. “байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хүн амын эрүүл мэндийг хамгаалах болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн талаар хүлээсэн үүргээ тусгай зөвшөөрөл эзэмшигч хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих” гэж заасны дагуу хяналт тавьж ажиллах.
- Төсвийн тухай хуулийн 25.8-д “Төсвийн ерөнхийлөн захирагч тусламж, хандив авсан тухай баримтын хувийг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн санд нэг сарын дотор хүргүүлнэ.” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.
- 2014 онд Нөхөн сэргээлтийн төсөл хэрэгжүүлсэн ААН-үүдтэй байгуулсан гэрээг “Эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийх аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах, үйл ажиллагаанд нь хяналт тавих журам”-д заасны дагуу дүгнэх

Сумын Засаг дарга нарт

- Уул уурхайн тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд Ашигт малтмалын тухай хуулийн 12.1.3. “байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хүн амын эрүүл мэндийг хамгаалах болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн талаар хүлээсэн үүргээ тусгай зөвшөөрөл эзэмшигч хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих” гэж заасны дагуу хяналт тавьж ажиллах.
- Төсвийн тухай хуулийн 25.8-д “Төсвийн ерөнхийлөн захирагч тусламж, хандив авсан тухай баримтын хувийг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн санд нэг сарын дотор хүргүүлнэ.” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.
- Байгаль орчин, Ногоон хөгжлийн сайдын 2014.01.06-ны өдрийн А-04 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам”-ын дагуу сумын Төрийн сангийн тусгай дансанд байршуулсан баталгааны мөнгөн хөрөнгийн орлогын төвлөрүүлэлт, зарцуулалтын жилийн тайланг жил бүрийн 12 дугаар сарын 15-ны дотор сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж байх.
- Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй ААН-үүдийн үйл ажиллагааг Ашигт малтмалын тухай хуулийн 37.2. “Байгаль орчны албанаас зөвшөөрөл авалгүйгээр ашигт малтмал эрэх, хайх, энэ хуулийн 35.4-т заасан комиссын шийдвэргүйгээр ашигт малтмал ашиглах үйл ажиллагаа эхлэхийг хориглох бөгөөд тухайн асуудлаар маргаан гарвал мэргэжлийн хяналтын байгууллагад гомдол гаргаж болно.” гэсэн заалтыг дагуу аймгийн БОАЖГазарт бүртгүүлсний дараа эхлүүлж байх.
- Ашигт малтмалын тухай хуулийн 38.1.1.”тусгай зөвшөөрөл авснаас хойш 30 хоногийн дотор байгаль орчны хяналтын алба болон хайгуулын талбай байрших сум, дүүргийн Засаг даргатай зөвшилцөн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө боловсруулах” гэж заасны дагуу боловсруулаагүй төлөвлөгөөг батлахгүй байх.
- Ашигт малтмалын тухай хуулийн 39.7. “Тухайн жилийн нөхөн сэргээлтийн ажлыг бүрэн хийгээгүй тохиолдолд сум, дүүргийн Засаг дарга болон мэргэжлийн хяналтын алба хамтран дараагийн жилийн олборлолтын ажлыг эхлүүлэхгүй байх эрхтэй.” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.

- Засгийн газрын 2010 оны 308-р тогтоолоор баталсан “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ын 3.3 дахь “Геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас бичил уурхайн зориулалтаар ашиглаж болох тухай дүгнэлт гарсан тохиолдолд сум, дүүргийн Засаг дарга нь сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын энэхүү журмын 2.2-т заасан шийдвэрийг үндэслэн өргөдөл гаргасан нөхөрлөлтэй бичил уурхайгаар ашигт малтмал олборлох тухай гэрээг нэг жилийн хугацаагаар байгуулна.” Гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга Э.Энхбат танаа

- Ашигт малтмалын тухай хуулийн 39.7. “Тухайн жилийн нөхөн сэргээлтийн ажлыг бүрэн хийгээгүй тохиолдолд сум, дүүргийн Засаг дарга болон Мэргэжлийн хяналтын алба хамтран дараагийн жилийн олборлолтын ажлыг эхлүүлэхгүй байх эрхтэй.” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах
- 2014 онд Нөхөн сэргээлт хийсэн газар олборлолт явуулж Ашигт малтмалын тухай хуулийн 7.3 дахь заалтыг зөрчсөн Хөх бүрдний эх ХХК-ний холбогдох албан тушаалтан болон аж ахуй нэгжид хуулийн дагуу хариуцлага ногдуулах.
- 2015 онд Өлзийт сумын нутагт нөхөн сэргээлт хийх нэрээр Ашигт малтмалын тухай хуулийн 7.3 дахь заалтыг зөрчин олборлолт явуулсан аж ахуй нэгжүүдийг шалгаж хуулийн дагуу хариуцлага ногдуулах.

Аймгийн БОАЖГ-ын дарга Х.Бат-Оргил танаа

- Ашигт малтмалын тухай хуулийн 39.3. “Байгаль орчныг нөхөн сэргээх арга хэмжээг бүрэн биелүүлээгүй тохиолдолд байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 39.1.9-д заасан хөрөнгөөр байгаль орчныг нөхөн сэргээх ажлыг мэргэшсэн байгууллагаар гүйцэтгүүлэх бөгөөд нэмж шаардагдах хөрөнгийг тусгай зөвшөөрөл эзэмшигчээс үл маргах журмаар гаргуулна.”, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 15.7-д заасан “байгаль орчныг хамгаалах, түүний баялгийн нөөцийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар төрийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагад аргачилсан туслалцаа, санхүүгийн дэмжлэг үзүүлэх” гэсэн заалтын дагуу БОАЖЯаманд асуудлыг тавьж шийдвэрлүүлж байх.
- Байгаль орчин, Ногоон хөгжлийн сайдын 2014.01.06-ны өдрийн А-04 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн

баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам"-ын дагуу хайгуулын нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж ажиллах.

Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг заалт нэг бүрээр гарган 2015 оны 12-р сарын 10-ны дотор албан тоотоор ирүүлнэ үү.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ё.СУГАРРАГЧАА


МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА
64101 Номгон, Баянхонгор сум
<http://www.bayankhongor.gov.mn>
Утас 70-44-50-18, Факс 70-44-32-06

2015-10-21 № 16/814
танай _____ -ны № _____ т

Тайланд санал хүргүүлэх тухай

Уул уурхайн нөхөн сэргээлтийн хөрөнгө төвлөрүүлэлт, зарцуулалт, үр дүнгийн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаад үзэхэд Зорилт 2 дээр Эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийх аж ахуйн нэгжийг журмын дагуу сонгон шалгаруулсан боловч журмын 2.2, 8.3 дахь заалтыг хэрэгжүүлээгүйгээс нөхөн сэргээлт хийх газрыг газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаагүй, аж ахуйн нэгжүүдээс барьцаа хөрөнгө аваагүй, сонгон шалгаруулалтад шалгарсан аж ахуйн нэгжүүд нь өмнөх онд нөхөн сэргээлт хийсэн талбайдаа сумын Засаг даргатай гэрээ байгуулан дахин нөхөн сэргээлт хийх нэрээр олборлолт явуулж байна гэжээ.

Нөхөн сэргээлт хийсэн талбайг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс "Нөхөн сэргээлт хийх газар, талбайн хэмжээ, солбицол батлах тухай" 2014 оны 04 дүгээр сарын 16-ны 54 дүгээр тогтоолоор баталсан бөгөөд аж ахуйн нэгжүүдээс нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгө болох 1209.0 сая төгрөгийг байршуулаагүй боловч аймгийн нийтийн эзэмшлийн зам, талбайд 1688.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажлыг хийсэн байна.

Мөн Зорилт 2.1 дэх хэсэгт аймгийн ИТХ-ын 2014 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 9/2 тоот тогтоолоор баталсан "Эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийх аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулж, үйл ажиллагаанд нь хяналт тавих журам"-ын үйлчлэл нь хүчин төгөлдөр хэвээрээ байна гэжээ. Тус журам нь 2014 оны 12 дугаар сарын 31-нд бүхэлдээ хүчингүй болсон 2015 онд аймгийн ЗДТГ-аас тус журмыг хэрэгжүүлээгүй болно.

Зорилт 3.1-т Орон нутгийн төсвийн байгууллагууд нь "Төсвийн тухай хууль"-д заасны дагуу хандив авсан талаарх мэдээ тайланг аймгийн Төрийн санд гаргаж өгөөгүй байна гэжээ. Аймгийн ОНХС-нд орж буй хандив нь төрийн сангийн дансаар дамжиж байгаа болно.

ДАРГА  Д.ЖАРГАЛСАЙХАН

116282

D:\Zasag darga-2015 on\Zasag dargin тоот А4-2015 on.docx


МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА
64101 Номгон, Баянхонгор сум
Утас, факс 73-44-25-04
E-mail: bayankhongor@audit.gov.mn

Г АЙМГИЙН ЗДТГ-ын САНХҮҮ, ТӨРИЙН
САНГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА
Д БОЛДБААТАРТ

2015.10.21 № 58

Г Зөрчил ярилгах тухай Г

Үндэсний аудитын газрын 2015 оны аудитын болон зөвлөлт үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Уул уурхайн нөхөн сэргээлтийн хөрөнгө төвлөрүүлэлт, зарцуулалт, үр дүнд хийсэн нийцлийн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Шинэжинст сумын ЗДТГ-аар 2013-2014 онд төвлөрсөн 2450,0 мянган төгрөгийг нөхөй устгах, 1000 цэцгийн баярын арга хэмжээ, чөдөрлөх суулганд худалдан авах, байгаль хамгаалах өдөр тэмдэглэх, баян материал худалдан авах болон нөхөн сэргээлтийн нэвчлэн хяналтад зарцуулсан шатахуун, Баянговь сум 2013-2014 онд төвлөрсөн 3000,0 мянган төгрөгийг ОНХС-ийн орлогоор бүртгэн зарцуулсан байна.

Энэ нь БОНХС-ны сайдын 2014.01.08-ны А-04 тоот тушаалаар батлагдсан Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журмын 6.5. "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болж, тусгай дансанд байршуулсан мөнгөн хөрөнгийг анхлуу журмд зааснаас бусад зориулалтаар ашиглах, зарцуулахыг хориглоно" гэсэн зөвлөлт зөрчил байна.

Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1.12-р заалт, Монгол улсын Ерөнхий аудитормын 2009 оны 47 тоот тушаалаар батлагдсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах" журмын 2.1.1 "Бусдад өгөх төлбөр тооцрог зөрүүтэй тооцоолж олгоосон" заалтыг үндэслэн ШААРДАХ НЬ:

Нэг. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн дагуу сумдын Төрийн сангийн дансанд байршуулсан хайгуулын тусгай зөрчилөөртэй ААН-үүдийн барьцааны мөнгийг зориулалт бусад зарцуулахгүй байх.

Хоёр. Хайгуулын барьцааны мөнгийг данс бүртгэлд зохих журмын, стандартын дагуу тусгаж, тайлагнаж байх.

515017

Гурва. Зөрчлийг баримдуулж, хариул 2015 оны 11-р сарын 15-ны дотор аймгийн Аудитын газарт ирүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Д.Болдбаатар, аймгийн ерөнхий нягтлан бодогч Ц.Самбууням нарт хариуцуулав.

Дээрх зөрчлийг арилгаагүй тохиолдолд Төрийн нудитын тухай хуулийн 28.2 "Дараах тохиолдолд зөрчил зогсоосон албан тушаалтмын үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хэрэглэнэ", 28.2.2 "төрийн нудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, талбарын актыг цаг хугацаанд нь биелүүлэхгүй тохиолдолд" гэсэн заалтын дагуу шийдвэрлүүлэх болно.

АЛБАН ШААРДЛАГЫГ
БИЧСЭН
АХЛАХ АУДИТОР  Б.МӨНХБАТ
ЗӨВШӨӨРСӨН
СТСХ-ийн ДАРГА
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ
Д.БОЛДБААТАР
Ц.САМБУУНЯМ

